



ISSUE #20

3 February 2012

## ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

1-р семестрийн хичээл дуусч дунд сургуулийн багш сурагчид маань 2-р семестрийн хичээлээ эхэллээ. Сурагчид маань ном уншиж ярилцан дүгнэлт хийж лабораторийн туршилтууд хийж гүйцэтгэлээ.

Математик болон хэлний хичээлээ давтаж, дизайн технологийн хичээлээр бүтээлч ажил хийхээр сурагчид маань шамдан суралцаж байна. Энэ бүхний үр дүнд сурагчид маань бүтээлчээр сэтгэн бодож, асуудлыг шийдэж, оролцоо сайтай иргэд болон төлөвшдөг юм.

Дунд сургуулийн сурагчдын жүжигт тоглох авъяаслаг сурагчдыг сонгох шалгаруулалт явагдаж, сагсны баг тамирчид ирэх долоо хоногт болох АСАМИС тэмцээнд оролцохоор Шанхай руу, охидын ансамблийн хэсэг сурагчид ирэх долоо хоногт Бээжинд болох концертонд оролцохоор явах гэж байна. Бид сурагчдаа дэмжиж, тэдэнд урам өгч бас тэднийг өөрсдийн боломжоор аливааг хамгийн сайнаар хийх шаардлагыг тэдэнд тавьдаг.

Сурагчдын сурлагын дүнгийн мэдээлэлийг та бүхэнд ирэх долоо хоногт явуулна. Та бүхэн хүүхдүүдтэйгээ энэ хичээлийн жилийн 1-р семестрийн туршид юу сурч мэдсэн талаар нь асууж ярилцаарай. Хэрвээ та бүхэнд асуух асуулт байвал би та нартай уулзаж ярилцахад баяртай байх болно. Надтай уулзах бол ресепшин Халиунаатай холбоо барьж уулзалтын цаг товлоорой.

Дааралгүй сайн дулаалж амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй!

**Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann**

# THE MEDEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar

### ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

2 сарын 8— Дунд Сургуулийн сурагчдын 1-р семестрийн дүн гарна

2 сарын 8-12— АСАМИС сагсны тэмцээн Хятадын Suzhou-д болно

2 сарын 14— 5-р ангийн үзэсгэлэнгийн уулзалт 8.30 -9.30 ОУДС номын санд

2 сарын 16— Дунд сургуулийн сурагчдын эцэг эхийн хурал (13:00-19:00)

2 сарын 16-18— АСАМИС Урлагийн Өдөрлөг Бээжин хотноо

2 сарын 21— Цагаан Сарын Өдөрлөг (13:40)- Сургуулийн Заланд

2 сарын 22-24— Цагаан Сарын баярын амралт— Хичээл орохгүй

**FRONT PAGE**— THE MEDEE IS AVAILABLE ONLINE EACH WEEK AT: [WWW.ISUMONGOLIA.EDU.MN](http://WWW.ISUMONGOLIA.EDU.MN)

# БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

## Суралцах үр чадварын арга барил

Шинэ семестр эхэлж байгаатай холбогдуулан гэртээ хэрэгжүүлж болох суралцах үр чадварыг хөгжүүлэх зарим нэгэн арга барилаас та бүхэнтэй хуваалцаж байна.

Таны хүүхэд аль хэдийн гэрийн даалгаварын хавтсаа хэрэглэж даалгавраа сурагчийн өдрийн тэмдэглэлдээ бичиж сурсан байгаа. Гэртээ очоод энэ үүргээ үргэлжлүүлэх нь чухал. Суралцах үр чадвар нь байнга тогтмол хэрэгжүүлсэнээр хөгждөг арга барил юм. Та бүхэн гэртээ энэ арга барилыг байнга тогтмол хэрэгжүүлж заншил болгоход нь сурагчдад туслах хэрэгтэй.

Хэрвээ та бүхэн үүнийг хэрэгжүүлдэггүй бол өдөр бүр гэрийн даалгавар хийх тогтмол цагийг хүүхэдтэйгээ хамт товлоорой. Хүүхэд чинь чимээгүй орчинд тогтмол сууж даалгавраа хийх нь чухал. Ширээн дээр зөвхөн даалгавраа хийхэд л хэрэглэгдэх зүйлс байх хэрэгтэй. Ширээн дээр өөр зүйл байвал хүүхдийн анхаарал амархан сарнина.

Бүх сурагчдын зайлшгүй эзэмших бас нэг үр чадвар бол цаг ашиглалт юм. Эхлээд хүүхэдтэйгээ даалгавар тус бүрийг хийж дуусгахад хэдий хугацаа орохыг төлөвлөөрэй. Тэгээд гал тогооны цагаа буюу сэрүүлэгтэй цагийг товлосон хугацаандаа тохируулж тавиарай. Тэгээд цаг болмогц та нарын товлосон цаг хэтэрхий хурдан, хэтэрхий удаан эсвэл яг тохирсон байсан талаар шалтгааныг нь ярилцаарай. Дараагийн удаа ижил төрлийн даалгавар гүйцэтгэхдээ түрүүчийн туршлага дээрээ үндэслэн даалгаврыг хийж дуусгах цагаа товлоорой. Даалгавраа тогтмол хийж цагийг урьдчилан товлож эргэцүүлэн бодсоноор хүүхдийн аливааг төлөвлөх, цагийг зөв ашиглах үр чадварыг хөгжүүлэхэд тустай.

Энэ хоёр энгийн аргыг хэрэгжүүлсэнээр хүүхэд тань суралцах үр чадвараа хөгжүүлж бие даан суралцаж амжилтанд хүрнэ.

## Сурлагын Дүнгийн Мэдээлэл

Лхагва гарагт сурлагын дүнг та бүхэнд явуулсан. Хүүхэдтэйгээ сурлагын дүнгийнх нь талаар ярилцаж гарын үсгээ зуран дугтуйг буцааж явуулсанд та нарт баярлалаа. Сурлагын дүнг нь та бүхэн хадгалж хэрвээ асуулт байвал хүүхдийнхээ багштай нь холбоо бариарай.

Амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй!

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya

## 5 дугаар ангийн сурагчдын эцэг эхийн анхааралд,

Өнгөрсөн 11 дүгээр сард үзэсгэлэнгийн хугацаанд зохиогдох ажлын талаар төлөвлөгөө гаргахаар та бүхэнтэй уулзахад маш сайхан байлаа. Харин одоо энэ төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэх цаг хугацаа хаяанд ирээд байна. 2 сарын 13-ны Даваа гарагт 5-р ангийн сурагчид маань арван долоо хоногийн хугацаатай үзэсгэлэнгийн ажлаа эхлэх гэж байна. Энэ үзэсгэлэнгийн ажлын хүрээнд бага сургуулийн төгсөх ангидаа сурагчид маань “нийгэмд тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрээ бага ч гэсэн оруулж чадна” агуулгатайгаар судалгааны ажлаа хийж үр дүнг нь тооцон гаргадаг.

Бүх 5-р ангийн сурагчид, эцэг эхчүүд та бүхнийг үзэсгэлэнгийн нээлтийн ажиллагаанд хүрэлцэн ирэхийг урьж байна. Энэ үеэр үзэсгэлэнгийн зорилго, шаардлага, эцэг эх, багш, сурагчдын үүргийн талаар та бүхэнд тайлбарлаж таны асуултад хариулт өгөх болно.

**2 сарын 14 ны Мягмар гарагийн 8:30-9:30 цагт ОУДС-ийн номын санд** болох манай уулзалтанд та бүхнийг хүрэлцэн ирнэ гэдэгт найдаж байна.

Gary Herbison, Liz Covington, Mags Faber

# Монгол Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театр

2012 ОНЫ 2 Р САРЫН ТОГЛОЛТ

|                   |  |
|-------------------|--|
| <b>04.02.2012</b> | <u>Б Шарав ЧИНГИС ХААН дуурь</u>                               |
| <b>05.02.2012</b> | <u>П.И.Чайковский ХУНТ НУУР балет</u>                          |
| <b>11.02.2012</b> | <u>Ж.Бизе КАРМЕН дуурь</u>                                     |
| <b>12.02.2012</b> | <u>Б.Дамдинсүрэн Б.Смирнов УЧИРТАЙ<br/>ГУРВАН ТОЛГОЙ дуурь</u> |
| <b>18.02.2012</b> | <u>А.Хачатурян СПАРТАК балет</u>                               |
| <b>19.02.2012</b> | <u>А.Хачатурян СПАРТАК балет</u>                               |

**Хаяг:** Монгол Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театр  
Отгонжаргал Менежер-99024933  
Алтанцэцэг ДБЭТ-н касс 70110389

Дэлгэрэнгүй мэдээлэл <http://www.opera-ballet.mn/>

Э. Сэлэнгэмөрөн  
Нийгмийн үйлчлэлийн ажилтан